

## Руни бичгийн дурсгал дахь хэлцийн орчуулга

Н.Гэрэлмаа /МУИС, ГХСС/

**Товч агуулга:** Эртний түрэг угсаатанд холбогдох руни бичгийн сонгодог дурсгалууд нь дан гагц түүхийн сурвалж бус уран зохиолын найруулгын өнгө аястай, яруу найргийн мөр, бадаг, тогтвортой хэлц хэллэгийг өөртөө багтаасан өвөрмөц найруулгаар зохиогдсон учир бусад хад чулуу, гэрэлт хөшөөний бичээсээс эрс ялгаатай юм. Түүхэн үнэн хэрэг явдлыг ийнхүү уран сайханаар үзүүлэх уламжлал нийт нүүдэлчин угсаатны дунд түгээмэл байсан аж. Уул дурсгалд тэмдэглэгдэн үлдсэн эртний түрэг угсаатны хэл-соёлын нэгэн илрэл болсон зарим хэлц хэллэгийг монгол хэлнээ хэрхэн орчуулсан байдал хийгээд утга дүйх хэлцээр оноон орчуулах боломжийг эрэлхийлсэн болно.

**Түлхүүр үг:** руни бичиг, сонгодог дурсгал, хэлцийн орчуулга

Монгол нутгаас олдсон эртний түрэг угсаатанд холбогдох руни бичгийн дурсгалууд нь хэл-түүх соёлын чухаг баримт болох бөгөөд агуулга, хэмжээний хувьд харилцан адилгүй байгаа билээ. Руни бичгийн сонгодог дурсгал хэмээн нэрлэж заншсан Келтигин, Билгэ хаан, Тоньюкукийн гэрэлт хөшөөний бичээсийг Түрэгийн ард түмний эв нэгдлийг эрхэмлэн өөрийн хүчирхэг төр улсыг байгуулсан түүхэн гавьяа зүтгэлийг хойч үедээ алдаршуулах зорилгоор сийлэн үлдээсэн байдаг. Дээрхи дурсгалуудад түүхэн хэрэг явдлыг ерийн тоочин өгүүлэх бус уран сайхны хэл найруулгын аргаар зохион бичсэн тул зөвхөн түүхэн дурсгал бус эртний түрэгийн хэл-уран зохиолын томоохон баримт, эх хэрэглэгдэхүүн болж байна.

Руни бичгийг анх тайлан уншсан түүхийг сөхөн үзвэл 1889 онд Н.М.Ядринцевийн удирдсан Оросын газарзүйн нийгэмлэгийн Дорнод Сибирийн салбарын шинжилгээний анги Монгол нутагт ирж ажиллахдаа Орхоны хөндийгөөс Келтигин, Билгэ хааны гэрэлт хөшөө бүхий цогцолбор дурсгалыг олж илрүүлэн дэлхий дахинд мэдээлсэн байна<sup>68</sup>. Харин 1893 онд Копенхагений их сургуулийн профессор В.Томсен “нууц, тайлагдашгүй” хэмээх руни бичгийг унших түлхүүр цагаан толгойг олж тогтоосноор уул бичээсүүдийн судалгаа эхэлсэн хэмээн үзэж болно. Өнөө уншиж тайлсаны 120 жилийн ой тохиож буй энэ хугацаанд эдгээр гэрэлт хөшөөний бичээсийг

<sup>68</sup> Н.М.Ядринцев, Отчет экспедиции на Орхон, совершенной в 1889 г. Поручению Восточно-Сибирского Отд.Географического Общества, -Сборник трудов Орхонской экспедиции 1, Санкт-Петербург, 1892; Н.М.Ядринцев, Предварительный отчет об исследованиях по р.Толе, Орхону и в Южном Хангае, - Сборник трудов Орхонской экспедиции 1, Санкт-Петербург, 1892, стр. 27-40; Н.М.Ядринцев, Отчет и дневник о путешествии по Орхону и в Южный Хангай в 1891 году, -Сборник трудов Орхонской экспедиции V, Санкт-Петербург, 1901, стр. 1-54

герман, орос, франц, мажар, япон, солонгос, монгол, англи гэх мэт хэлээр орчуулсан буй.

Орчуулгад ихээхэн анхаарвал зохих зүйлсийн нэг бол тухайн хэлт үндэстний соёл, зан заншил, шашин шүтлэг, ертөнцийг үзэх үзлийн нэгэн тусгал болсон тогтвортой хэллэгийн орчуулга билээ. Бид энэхүү судалгаандаа сонгодог гурван дурсгалын хэл найруулгад чимэг болгон оруулсан хэлц, хэллэгийг монгол хэлнээ хэрхэн “идээшүүлэн” буулгаж болох талаар саналаа нэмэрлэхийг зорилоо. Үүний тул даархи мэт гурван зүйл болгон авч үзэв.

1. Өвөрмөц хэлцийн орчуулга:

**kızı qaşı yablaq boltaçı tip saqıntım** [Келтигин, Хойт тал. 11]

Үгчилсэн орчуулга: нүд хөмсөг нь дорой болох мэт санав би.

Утга дүйлгэсэн орчуулга: ...зовхи нь буух мэт санав би.

Б.Базылхан: ...нүд хөмсөг нь бүлтийх вий гэж санав.

Л.Болд: ... нүд нь бөлцийн хавдаж зовхи нь буусан шиг санагдав.

Тайлбар: Бичээст гарах хам сэдвийн хүрээнд авч үзвэл Билгэ хаан дүү Келтигинийг нас барахад эмгэнэн гашуудаж хэлсэн үгэндээ “... eki şad ulayu iniуьгьньм, оуланım, beglerim, bodunum kızı qaşı yablaq boltaçı tip saqıntım - ...хоёр шад тэргүүтэй ах дүүс, үр ач, ноёд, ард түмэн минь зовхи нь буух мэт санав би” хэмээжээ. Өөрөөр хэлбэл Келтигинийг үгүй болоход ах дүү, ард түмэн нь цөм уй гашууд автсаныг Билгэ хааны өгүүлж байгаагаар ийн бичжээ.

**uda basdımız** [Келтигин, зүүн тал. 35, 37]

Үгчилсэн орчуулга: ... нойронд дарав бид.

Утга дүйлгэсэн орчуулга: ... гэнэдүүлэн дарав бид.

Б.Базылхан: ... нойр дээр нь дарав бид.

Л.Болд: ... унтаж байхад нь довтлон орж даран сөнөөв.

Тайлбар: Энэхүү хэлцийн бүтцэд байх *uda-* гэх үгийг *u-*(нойр хэмээх нэр үг) + *da*(оршихын тийн ялгалын нөхцөл) болох бөгөөд энд ямар нэг биед хамаатуулах нөхцөл аваагүй байна. Иймээс хойноо авсан үйл үгтэй утгын хувьд нэгдэн нэгэн бүхэл утга санаа илтгэж байгаа болно.

**teñri tırьsinte tutup уьгерь кцърмиш еринч** [Келтигин, зүүн тал. 11]

Үгчилсэн орчуулга: тэнгэр дээрээс нь барьж дээшээ аваачсан бөлгөө.

Утга дүйлгэсэн орчуулга: тэнгэр ивээж тэргүүнд залсан билээ.

Б.Базылхан: тэнгэр дээр шиг бишрэн шүтэж өргөмжилсөн билээ.

Л.Болд: тэнгэр зулайгаас нь өргөн дэвшүүлэв.

Тайлбар: Эл хэсэгт бидний үзэж байгаагаар “*tırьsinte tut-*” буюу “дээрээс нь барих”, “*уьгерь кцър-*” буюу “дээшээ аваачих” гэсэн хоёр өвөрмөц хэлц байна. Хам сэдэвт “*qarıм ilteriş qayanıу цьгьм ilbilge qatunıу teñri tırьsinte tutup уьгерь кцърмиш еринч*”

– хан эцэг Илтериш хааныг, эх Илбилгэ хатныг тэнгэр ивээж тэргүүнд залсан билээ” хэмээн гарч буй. “Дээр тэнгэр, Түрэгийн ариун дагшин газар ус түрэг түмнийг битгий үгүй болоосой” хэмээн тэргүүнд нь хан эцэг, хатан эхийг залсан болохыг энэхүү хэлцээр гаргажээ.

**izre ašsız tašra tonsuz** [Көлтигин, зүүн тал. 26]

Үгчилсэн орчуулга: дотроо хоолгүй, гаднаа хувцасгүй

Утга дүйлгэсэн орчуулга: явган нүцгэн

Б.Базылхан: дотроо хоолгүй, гаднаа дээлгүй

Л.Болд: амандаа идэх хоолгүй, мөрөндөө өмсөх дээлгүй\ дотроо хоолгүй, гаднаа дээлгүй

**kergek<sup>69</sup> bolmiş** [Көлтигин, зүүн тал. 4, 30, хойт тал.10]

Үгчилсэн орчуулга: хэрэг болжээ.

Утга дүйлгэсэн орчуулга: Таалал төгсөв, насан эцэслэв, өөд болов.

Б.Базылхан: таалал төгссөн юм.

Л.Болд: насан эцэслэв.

Тайлбар: Бичээст тохиолдох хэлцийн давтамжаас үзэхэд энэхүү хэлцийг “үхэх” гэдгийн хүндэтгэсэн найруулгад хэрэглэж байгаа нь тодорхой байна. Түрэг улсын цэргийн жанжин Көлтигинийг нас барсаныг [тэнгэрт] “хэрэг болов” хэмээн өгүүлж байгаа нь эртний түрэгүүдийн тэнгэр шүтлэгтэй холбоотой үүссэн хэлц болов уу.

**usin buntutu yurtda yatu qalur erti** [Тоньюкук, зүүн тал. 2]

Үгчилсэн орчуулга: нойроо хаяж хээр хэвтэн үлдэж билээ.

Утга дүйлгэсэн орчуулга: нойроо умартан хээрээр гэр, хэцээр дэр хийж байв.

Л.Болд: Усун бунтатугийн нутагт суурьшин [тэндээ амьдарч] үлдэх байсан юм.

А.Амар: Үшин Будатуг хаав.

Тайлбар: Хэлцийн бүтцэд байх эхний хоёр үгийг судлаачид газрын нэр мэтээр ухаарсан байна. Гэвч “buntut-зугатаалгах” гэх үгийн утгаас үүдэн бид “нойроо хаях, гээх” гэж орчуулах нь зүйтэй хэмээн үзлээ. Харин “yurtda yatu qal-хээр хэвтэж үлдэх” гэсэн хэлцийг “хээрээр гэр хийх” –тэй утга дүйлгэв.

**adaq gamšatdı** [Көлтигин, хойт тал. 7]

Үгчилсэн орчуулга: хөл гуйвав, салганан чичрэв.

Утга дүйлгэсэн орчуулга: хүч мөхөстөв, доройтов

Б.Базылхан: тамирдав.

Л.Болд: туйлдан ядрав.

---

<sup>69</sup> Энэхүү үгийг эртний түрэг хэлний толь бичигт “хэрэгтэй, шаардлагатай” хэмээсэн утгатай болохыг тэмдэглэжээ.

**ot sub qilmadım** [Көлтигин, зүүн тал. 27]

Үгчилсэн орчуулга: гал ус болгосонгүй би.

Утга дүйлгэсэн орчуулга: дайсан болгосонгүй би.

Б.Базылхан: гал усанд автуулсангүй би.

Л.Болд: гал ус болгон харшилдуулсангүй.

2. Хэвшмэл хэлцийн орчуулга:

**ud tengri aysar kiši oylı qop ulgeli tırımıš** [Көлтигин, хойт тал. 10]

Үгчилсэн орчуулга: цагийн тэнгэр хэлбэл хүний хүү цөм үхэхээр төржээ.

Утга дүйлгэсэн орчуулга: “Цагийн” тэнгэр зарлиглавал хүний хүү цөм үхэхээр заяагджээ.

Б.Базылхан: тэнгэр бүтээх үед хүний хөвүүн олноор үхэх гэж төрсөн юм.

Л.Болд: тэнгэр бурханы таалсан цаг ёсоор хүний хүү бүгд үхэхээр төрдөг.

Тайлбар: Хэлцийн бүтцэд буй “aysar” гэх үгийг үгийн бүтцээр задлан үзвэл ау- (хэлэх, өгүүлэх гэсэн утгатай үйл үндэс) + sar(болзох төлөвийн нөхцөл) болно. Судлаачид монгол хэлний “айлтгах, айлдах” мөн түүнчлэн “ай” гэх аялга үгсийг нэг гаралтай хэмээн үзэж буйгаас харахад уул үгийн хүндэтгэх найруулгын утга монгол хэлнээ хадгалагдан үлдсэн нь тодорхой байна.

**turuq buqalı semiz buqalı ıraqda bilser**

**semiz buqa turuq buqa teyin bilmez ermiš** [Тоньюкук, баруун тал. 5.6]

Үгчилсэн орчуулга: туранхай бух тарган бухыг холоос мэдвэл тарган туранхай бух гэж мэдэхгүй бөлгөө.

Утга дүйлгэсэн орчуулга: бухыг холоос хараад тарган туранхайг ялгахад бэрх бөлгөө.

Л.Болд: туранхай бухтай, тарган бухтай [үхэр сүрэг] алсад бэлчиж байвал [хүмүүс] энэ нь тарган бух, тэр нь туранхай бух гэж ялгаж мэдэхгүй.

А.Амар: холоос тарган буга туранхай буга хоёрын тарган туранхайг ялгахад бэрх хэмээлээ би.

Тайлбар: Түрэгийн мэргэн сайд Тоньюкукийн хэлсэн энэ үг “...Түрэг түмнийг хураан нэгтгэсний дараа шударга, үнэнч хааныг олж хаан ширээнд зална” гэдэг бол “бухыг холоос хараад тарган туранхайг ялгахад бэрх” байгаатай адил юм гэсэн утга агуулгатай хэлц юм.

**yuyqa erkli topulıyalı ućuz ermiš**

**yinćgd erklig ызgeli ućuz**

**yuyqa qahn bolsar topulıuluq alp ermiš**

**yinćgd yoğun bolsar ызgьlk alp ermiš** [Тоньюкук, өмнө тал. 6]

Үгчилсэн орчуулга: нимгэн байхад нугалахад хялбар бөлгөө, нарийн байхад хугалахад хялбар бөлгөө. Нимгэн нь зузаан болвол нугалах хэцүү бөлгөө, нарийн нь бүдүүн болвол хугалах хэцүү бөлгөө.

Л.Болд: [ямар нэг юмыг] нимгэн [ахуйд] нугалахад хялбар, нарийн [ахуйд] хугалахад амар, нимгэн юм том болоход [түүнийг] нугалахад баатар [зориг] хэрэгтэй, нарийн юм зузаан болбол [түүнийг] урахад баатар [зориг] хэрэгтэй.

А.Амар: ямар нэг юмыг зөөлөн ахуй доор түүнийг нугалах хялбар. Нимгэн ахуй доор түүнийг урах хялбар. Хэрэв зөөлөн юм хатуу болохул түүнийг нугалахад баатар зориг хэрэгтэй. Нимгэн юм зузаан болох ахуй түүнийг урахад баатар зориг хэрэгтэй.

Тайлбар: монгол орчуулгаас харахад утгын хувьд зөрүү байхгүй хэдий ч “alp” буюу баатар гэх үгийн утгаас үүдэн гагц энэ үгийг “баатар зориг хэрэгтэй” гэж буулгасан байна. Бидний санахад энэ үгийн бичээст тохиолдох давтамжаас үзэхэд “эрэлхэг, баатар, дийлдэшгүй” гэх тэмдэг нэрийн үүргээр гарч байгаа тул “хэцүү, бэрх” гэсэн утгаар ойлгох боломжтой ажээ.

### 3. Зарим хэллэгийн орчуулга:

**kuzde yaş kelser tıda kuңғылтд sıyt kelser yanturu saqıntım**[Көлтигин, Хойт тал 11]

Үгчилсэн орчуулга: нүдэнд нулимс ирвэл барьж зүрхэнд гуниг ирвэл буцааж санав би  
Утга дүйлгэсэн орчуулга: нулимсаа барьж зүрхээ чангалан...

Б.Базылхан: нүдэндээ нулимс гүйлгэнэн ирвэл бие сэтгэл хөдлөн уйлахад хүрвэл дахин санав би.

Л.Болд: нүдэнд хурсан нулимсаа хүчээр тогтоон, зүрхэнд хурсан уй гунигаа хүчээр даран сарниаж бие сэтгэлээ ихэд барив.

Тайлбар: Энэхүү хэллэг дүү Көлтигинийг нас барахад Билгэ хааны хэлсэн гашуудлын үгэнд гарч буй. Утга агуулгын хувьд “тэнгэр зарлиглавал” “хүн төрсөний эцэст үхдэг жамтай” тул “сэтгэлээ барьж зүрхээ чангалав би” хэмээх мэт болно.

**цльgi yurtda yolta yatu qaltaǰı ertigiz** [Көлтигин, хойт тал. 9]

Үгчилсэн орчуулга: үхэгсэд нь хөдөө, замд хэвтэж үлдэх бөлгөө, бид)

Утга дүйлгэсэн орчуулга: үхэж үрэгдсэн нь хээр хөдөө, зам зуур хаягдах\орхигдох болно.

Б.Базылхан: үхдэл нь буйранд, замдаа хаягдах болуузай.

Л.Болд: үхэгсэд нь нутагтаа, зам зууртаа хэвтэн үлдэх байлаа.

Тайлбар: Хэллэгт байх “yatu qal-хэвтэж үлдэх” гэх хэлц нь “хаягдах, орхигдох” гэх нэгэн утга илтгэж байгаа хэмээн санана.

**ьze tengri basmasar asra yer telinmeser** [Көлтигин, зүүн тал. 22]

Үгчилсэн орчуулга: дээд тэнгэр дарахгүй бол, доор газар цоорохгүй бол

Утга дүйлгэсэн орчуулга: Тэнгэр нурж газар цөмрөхгүй бол...

Б.Базылхан: дээрээ тэнгэр дарахгүй бол, дороо газар тэлэхгүй бол

Л.Болд: дээр тэнгэр нураагүй юм бол, доор газар цөмрөхгүй юм бол...

**otča borča kelti** [Көлтигин, зүүн тал. 37]

Үгчилсэн орчуулга: гал мэт шуурга мэт ирлээ.

Утга дүйлгэсэн орчуулга: гал мэт, шуурга мэт дайран ирлээ.

Б.Базылхан: Гал шиг улангасан, дарс шиг эрслэн ирлээ.

Л.Болд: гал шиг дүрэлзэн, дарс шиг шуугин ирэв.

Тайлбар: Эртний түрэг хэлний толь бичигт “bog” гэх үгийг “шуурга, цасан шуурга, хар шуурга” хэмээсэн утгатай болохыг тэмдэглэсэн байдаг.[Наделяев В.М...,1969, стр.113] Орчин цагийн түрк хэлэнд их шуургыг “bogan” гэж буй. Харин монгол хэлэнд энэхүү үг эрт үедээ мөн адил “салхи, шуурга” гэсэн утгатай<sup>70</sup> байсан бол өнөө “хур бороо” болон утга өөрчлөгдсөн байна.

Энэ мэтчилэн руни бичгийн дурсгалд гарах хэлц хэллэгийг монгол хэлнээ дүйлгэн орчуулахад 1. Үгчилсэн орчуулгаас үүдэн хэлцийн нэгдмэл утга алдагдаж байгааг, 2. Монгол хэлний бэлэн хэлц, хэллэгээр дүйлгэн орчуулахад түрэг угсаатны соёлын онцлогийг хадгалан үлдсэн хэлний нэгжийг орхигдуулах сөрөг тал ажиглагдаж байгааг дурдах хэрэгтэй.

## Резюме

Надписи на памятнике являются не только языковыми и историческими памятниками, а также литературными. В данной надписи были искусно использованы методы художественной литературы как идиом и фраз.

Традиции художественного изложения исторических событий постоянно встречаются у кочевых народов.

И так, автор данной статьи считает что, кроме лингвистического исследования памятника, следует глубоко анализировать со стороны литературы и стилистики.

## Ашигласан ном, эх хэрэглэгдэхүүн

Кирилл үсгээрхи:

1. Амар А. Монголын товч түүх, Улаанбаатар, 1989
2. Базылхан Б, Күл-тегиний хөшөөний бичээсийн монгол орчуулга, Хэл зохиол, Том. XVI, fasc. 1-19, Улаанбаатар, 1987, 45-67-р тал.
3. Болд Л, Орхон бичгийн дурсгал III, Улаанбаатар, 2010
4. Болд Л, Орхон бичгийн дурсгал IV, Улаанбаатар, 2011
5. Наделяев В.М..., Древнетюркский словарь. М-Л., 1969
6. Ядринцев Н.М., Отчет экспедиции на Орхон, совершенной в 1889 г. Поручению Восточно-Сибирского Отд.Географического Общества, -Сборник трудов Орхонской экспедиции 1, Санкт-Петербург, 1892

<sup>70</sup> “Монголын Нууц Товчоон”-ы 108 зүйлд “jamuqa ьгыльгьн **boro`an** ber bolu`asu boljal-tur qura ber bolu`asu qural-tur bu qojidaya” хэмээн гардаг.

7. Ядринцев Н.М., Предварительный отчет об исследованиях по р.Толе, Орхону и в Южном Хангае, -Сборник трудов Орхонской экспедиции 1, Санкт-Петербург, 1892, стр.

27-40

8. Ядринцев Н.М., Отчет и дневник о путешествии по Орхону и в Южный Хангай в 1891

году, -Сборник трудов Орхонской экспедиции V, Санкт-Петербург, 1901, стр. 1-54

Латин үсгээрхи:

1. Orhun H.N, Eski türk yazıtları, Ankara, 1986

2. Tekin T, Orhon yazıtları, Kыltigin, Bilge kağan, Tunyukuk, İstanbul, 2003

3. Tekin T, Tunyukuk yazıtı, İstanbul, 1993